**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүрээ амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СНАГ-2024/16/НА-СТА-ТШ3**


Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот 2024 он

**Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,**

**тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг**

Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

**Аудитын менежер: Ц.Хосжаргал**

Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn

**Аудитор: Б.Ариунжаргал**

Утас: 262071 Цахим хаяг: ariunjargalb@audit.gov.mn

**“Тэд-Аудит” ХХК-ийн ерөнхий захирал: Ц.Сугармаа**

Утас: 99151254 Цахим хаяг: ted.audit.llc@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.23 № 07/311

танай ____________-ны № ____________-т

"ХҮРЭЭ АМАРЖИХ ГАЗАР" ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛГИЙН ЗАХИРАЛ Б.МӨНХСАЙХАН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүрээ амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүрээ амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Хүрээ амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах тухай" гэрээний 2.4.2-т "төсвийн тухай хуульд заасан санхүүгийн тайлангийн цаглавартай холбогдуулан тухайн төсвийн жилийн 6, 12 дугаар сард үзүүлсэн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг тухайн сарын 10-ны өдрөөр тасалбар болгох...., "11-ний өдрөөс сар дуусах хугацаанд үзүүлсэн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг дараа сарын нэхэмжлэхтэй хамтатган хүргүүлэх" гэж заажээ.

Ингэснээр нийт 195,150.0 мянган төгрөгийн санхүүжилтийг тайлант жилийн гүйцэтгэлд тооцоогүй, тухайн байгууллагын орлогыг бууруулж, өр авлагыг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан баталгаажуулах боломжгүй болгож байгаа нь Төсвийн тухай хуулийн 7.1, 7.3, 43.5-д заасан "төсвийн жил нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно", "төсвийг нэг жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан хэрэгжилтийг зохион байгуулах", "төсвийн захирагч нь төсвийг 2 төсвийн жил дамжуулан зарцуулахгүй" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

**Аудитын гол асуудал**

Засгийн газрын 2021 оны 352 дугаар тогтоолоор "Нийслэлийн хүрээ амаржих газар"-ыг Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний шууд харьяалагдах "Хүрээ амаржих газар" төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг болгон өөрчлөн зохион байгуулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 460 дугаар тогтоолоор тус эмнэлгийг үйл ажиллагаа, чиг үүргийн хувьд Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяалалд шилжүүлсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамруулаагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,046,123,894.63** | **681,997,644.47** |
| **31** | **МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ** | **255,673,670.20** | **2,880,276.87** |
| 312 | Банканд байгаа бэлэн мөнгө | 255,673,670.20 | 2,880,276.87 |
| 3121 | Төгрөг | 255,673,670.20 | 2,880,276.87 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 255,673,670.20 | 2,880,276.87 |
| **33** | **АВЛАГА** | **1,228,916.54** | **64,381,496.54** |
| 33300 | Татаас санхүүжилтийн авлага | - | 63,152,580.00 |
| 335 | Бусад авлага | 1,228,916.54 | 1,228,916.54 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 1,228,916.54 | 1,228,916.54 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **789,221,307.89** | **614,735,871.06** |
| 351 | Түүхий эд материал | 647,513,368.68 | 443,923,819.05 |
| 35130 | Эм боох материал | 647,513,368.68 | 443,923,819.05 |
| 354 | Хангамжийн материал | 141,707,939.21 | 170,812,052.01 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,408,016.00 | 5,067,361.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 54,901,689.00 | 71,877,564.50 |
| 35440 | Түлш шатах тослох материал | 1,283,120.00 | 816,540.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 82,115,114.21 | 93,050,586.51 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **5,343,067,022.60** | **5,253,609,340.20** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **5,343,067,022.60** | **5,253,609,340.20** |
| 392 | Биет хөрөнгө | 5,112,197,622.60 | 5,022,739,940.20 |
| 39201 | Барилга, байгууламж | 1,308,408,779.90 | 1,308,408,779.90 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (276,519,012.02) | (845,379,157.46) |
| 39203 | Авто тээврийн хэрэгсэл | 363,843,880.00 | 363,843,880.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (164,988,113.84) | (201,372,501.80) |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж | 7,075,513,662.51 | 7,503,589,545.81 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (3,291,171,413.21) | (3,249,348,563.92) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 161,913,117.67 | 213,830,137.97 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (64,855,801.71) | (80,784,703.60) |
| 39217 | Номын фонд | 52,523.30 | 9,952,523.30 |
| 393 | Биет бус хөрөнгө | 230,869,400.00 | 230,869,400.00 |
| 39301 | Программ хангамж | 1,300,000.00 | 800,000.00 |
| 39302 | Хасагдуулга | (1,300,000.00) | (800,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 230,869,400.00 | 230,869,400.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **6,389,190,917.23** | **5,935,606,984.67** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | **1,643,987.99** | **221,032,985.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **1,643,987.99** | **221,032,985.00** |
| 413 | Өглөг | 1,643,987.99 | 221,032,985.00 |
| 41310 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | 1,643,987.99 | - |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 220,830,173.00 |
| 4136 | Бусад өглөг | - | 202,812.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 202,812.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **6,387,546,929.24** | **5,714,573,999.67** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 6,387,546,929.24 | 5,714,573,999.67 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 2,195,199,872.60 | 2,195,199,872.60 |
| 51101 | Өмч: -Төрийн өмч | 2,195,199,872.60 | 2,195,199,872.60 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 3,697,339,688.74 | 3,024,366,759.17 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3,697,339,688.74 | 3,697,339,688.74 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (672,972,929.57) |

| | | | |
|---|---|---|---|
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 495,007,367.90 | 495,007,367.90 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **6,389,190,917.23** | **5,935,606,984.67** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **6,904,623,330.00** | **7,218,556,820.28** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **68,785,763.00** | **1,029,799,447.28** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 65,607,377.00 | 1,029,799,447.28 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 65,607,377.00 | 143,132,781.73 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 65,607,377.00 | 124,110,461.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 19,022,320.73 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан -Үндсэн хөрөнгө | - | 648,090,012.30 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан -Бараа материал | - | 238,576,653.25 |
| 122 | Тусламжийн орлого | 3,178,386.00 | - |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 3,178,386.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **6,835,837,567.00** | **6,188,757,373.00** |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,577,455,834.00 | 302,007,003.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид | 1,577,455,834.00 | 302,007,003.00 |
| 1330 | Төсвийн захирагчдаас | 350,000.00 | - |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 350,000.00 | - |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс | 5,258,031,733.00 | 5,886,750,370.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас | 5,258,031,733.00 | 5,886,750,370.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **5,957,608,303.29** | **7,890,899,632.79** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,957,608,303.29** | **7,890,899,632.79** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **5,891,048,773.29** | **7,790,387,937.79** |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 3,503,096,836.73 | 4,418,755,548.88 |
| 210101 | Цалин | 1,989,645,389.87 | 2,288,344,550.51 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 1,119,776,314.75 | 1,685,018,790.99 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 170,477,405.01 | 208,015,771.12 |
| 210104 | Урамшуулал | 223,197,727.10 | 237,376,436.26 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 452,375,205.29 | 543,197,540.10 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 440,366,446.29 | 379,082,551.23 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 3,033,457.00 | 43,619,688.78 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 2,426,765.00 | 31,286,203.42 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 589,895.00 | 8,595,511.21 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 5,958,642.00 | 80,613,585.46 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 123,785,701.23 | 154,559,371.34 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 38,260,597.55 | 63,046,842.63 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 24,689,581.68 | 31,029,067.71 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 60,835,522.00 | 60,483,461.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 164,533,885.05 | 428,112,408.30 |
| 210401 | Бичиг хэргийн материал | 8,427,410.30 | 27,323,232.00 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 6,426,480.00 | 8,111,480.00 |
| 210403 | Шуудан холбоо интернэтийн төлбөр | 5,059,669.65 | 6,276,810.00 |
| 210405 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 28,288,950.00 | 25,158,941.00 |
| 210406 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 51,793,095.00 | 67,294,486.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 64,538,280.10 | 293,947,459.30 |
| 2105 | Норматив зардал | 1,127,138,465.35 | 1,359,185,352.53 |
| 210501 | Эм | 991,055,365.35 | 1,137,073,552.53 |
| 210502 | Хоол | 136,083,100.00 | 219,111,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 3,000,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 17,896,330.00 | 9,314,800.00 |
| 210601 | Багаж хэрэгсэл | 12,830,440.00 | 776,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,065,890.00 | 8,538,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 29,425,825.50 | 47,757,194.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,670,800.00 | 27,955,335.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 9,500,000.00 | 14,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээний төлбөр | 475,720.00 | 548,220.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 508,160.00 | 278,912.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 99,000.00 | 99,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,496,252.00 | 2,997,000.00 |
| 210808 | Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 47,100.00 | 50,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягтын зардал | 3,628,793.50 | 1,828,727.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 472,796,524.14 | 829,505,722.64 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,812,386.00 | 11,895,100.00 |
| 210902 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 8,651,964.00 | 37,441,985.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 450,332,174.14 | 780,168,637.64 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **66,559,530.00** | **100,511,695.00** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 66,559,530.00 | 100,511,695.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 55,095,732.00 | 95,824,982.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 11,463,798.00 | 4,686,713.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)** | **947,015,026.71** | **(672,342,812.51)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)** | **-** | **630,117.06** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 630,117.06 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)** | **-** | **(630,117.06)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)** | **947,015,026.71** | **(672,972,929.57)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Балансын зүйл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **6,811,889,392.00** | **6,268,737,574.73** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **68,785,763.00** | **143,132,781.73** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 65,607,377.00 | 143,132,781.73 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 65,607,377.00 | 143,132,781.73 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 65,607,377.00 | 124,110,461.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 19,022,320.73 |
| 122 | Тусламжийн орлого | 3,178,386.00 | - |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 3,178,386.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **6,743,103,629.00** | **6,125,604,793.00** |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,577,455,834.00 | 302,007,003.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид | 1,577,455,834.00 | 302,007,003.00 |
| 1330 | Төсвийн захирагчдаас | 350,000.00 | - |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 350,000.00 | - |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 5,165,297,795.00 | 5,823,597,790.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 5,165,297,795.00 | 5,823,597,790.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)** | **6,581,017,810.90** | **6,478,279,908.06** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **6,581,017,810.90** | **6,478,279,908.06** |
| **210** | **БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **6,514,607,280.90** | **6,377,768,213.06** |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 4,092,716,928.71 | 4,420,530,361.37 |
| 210101 | Үндсэн цалин | 1,841,517,322.40 | 2,300,808,854.14 |
| 210102 | Нэмэгдэл | 1,857,524,474.20 | 1,679,039,220.85 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 170,477,405.01 | 206,995,480.98 |
| 210104 | Үр дүнгийн урамшуулал | 223,197,727.10 | 233,686,805.40 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 653,668,718.28 | 543,066,715.60 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 641,659,959.28 | 370,816,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 3,033,457.00 | 43,625,499.98 |
| 210203 | ҮОМШӨ-ий даатгалын шимтгэл | 2,426,765.00 | 34,900,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 589,895.00 | 8,725,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 5,958,642.00 | 84,999,015.62 |
| 2103 | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал | 135,317,166.23 | 154,559,371.34 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 49,792,062.55 | 63,046,842.63 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 24,689,581.68 | 31,029,067.71 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 60,835,522.00 | 60,483,461.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 79,605,921.65 | 84,672,378.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,315,610.00 | 16,903,660.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,250,000.00 | 7,661,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,350,456.65 | 6,276,810.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 24,414,935.00 | 23,952,526.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 36,274,920.00 | 29,877,482.00 |
| 2105 | Норматив зардал | 1,441,357,999.03 | 1,026,284,419.75 |
| 210501 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,255,668,349.03 | 787,245,119.75 |
| 210502 | Хоол, хүнс | 168,405,150.00 | 219,111,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 17,284,500.00 | 19,927,500.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 37,040,816.00 | 26,054,800.00 |
| 210601 | Багаж техник хэрэгсэл | 23,973,716.00 | 12,691,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 13,067,100.00 | 13,362,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 43,299,327.00 | 60,226,657.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 15,531,800.00 | 38,948,635.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 9,500,000.00 | 14,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 475,720.00 | 548,220.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 508,160.00 | 278,912.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 99,000.00 | 99,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,496,252.00 | 2,997,000.00 |
| 210808 | Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 47,100.00 | 50,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 15,641,295.00 | 3,304,890.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 31,600,404.00 | 62,373,510.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,388,090.00 | 28,184,710.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,212,314.00 | 34,188,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **66,410,530.00** | **100,511,695.00** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 66,410,530.00 | 100,511,695.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 55,095,732.00 | 95,824,982.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 11,314,798.00 | 4,686,713.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **230,871,581.10** | **(209,542,333.33)** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **-** | **43,251,060.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **43,251,060.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 43,251,060.00 |
| 225102 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал /ТӨҮГ/ | - | 43,251,060.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-** | **(43,251,060.00)** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **230,871,581.10** | **(252,793,393.33)** |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 25,152,089.10 | 255,673,670.20 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 255,673,670.20 | 2,880,276.87 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| № | ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2022 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл** | **2,195,199,872.60** | **514,104,470.78** | **(1,658,771,487.57)** | **1,050,532,855.81** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 13,983,812.88 | 13,983,812.88 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,195,199,872.6 | 514,104,470.78 | (1,644,787,674.69) | 1,064,516,668.69 |
| 4 | Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн | - | (19,097,102.88) | - | (19,097,102.88) |
| 7 | Тайлант үеийн үр дүн | - | - | 5,342,127,363.43 | 5,342,127,363.43 |
| **8** | **2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **2,195,199,872.60** | **495,007,367.90** | **3,697,339,688.74** | **6,387,546,929.24** |
| 9 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 10 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,195,199,872.60 | 495,007,367.90 | 3,697,339,688.74 | 6,387,546,929.24 |
| 11 | Тайлант үеийн үр дүн | - | - | (672,972,929.57) | (672,972,929.57) |
| 12 | **2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **2,195,199,872.60** | **495,007,367.90** | **3,024,366,759.17** | **5,714,573,999.67** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Данс | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 6,879,699,800.00 | 6,521,530,968.06 | 358,168,831.94 | 95.0 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 6,879,699,800.00 | 6,521,530,968.06 | 358,168,831.94 | 95.0 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 6,453,699,800.00 | 6,421,019,273.06 | 32,680,526.94 | 99.5 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 4,442,550,400.00 | 4,420,530,361.37 | 22,020,038.63 | 99.5 |
| 210101 | Үндсэн цалин | 2,410,236,100.00 | 2,300,808,854.14 | 109,427,245.86 | 95.5 |
| 210102 | Нэмэгдэл | 1,426,056,100.00 | 1,679,039,220.85 | (252,983,120.85) | 117.7 |
| 210103 | Унаа, болон бусад нөхөн олговор | 281,774,800.00 | 206,995,480.98 | 74,779,319.02 | 73.5 |
| 210104 | Урамшуулал | 324,483,400.00 | 233,686,805.40 | 90,796,594.60 | 72.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 545,318,700.00 | 543,066,715.60 | 2,251,984.40 | 99.6 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 370,816,700.00 | 370,816,700.00 | - | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 43,625,500.00 | 43,625,499.98 | 0.02 | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ- ий даатгал | 34,900,400.00 | 34,900,400.00 | 0.00 | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,725,100.00 | 8,725,100.00 | - | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 87,251,000.00 | 84,999,015.62 | 2,251,984.38 | 97.4 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 155,460,100.00 | 154,559,371.34 | 900,728.66 | 99.4 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 58,315,400.00 | 63,046,842.63 | (4,731,442.63) | 108.1 |
| 210302 | Түлш, халаалт | 37,971,000.00 | 31,029,067.71 | 6,941,932.29 | 81.7 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 59,173,700.00 | 60,483,461.00 | (1,309,761.00) | 102.2 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 84,475,200.00 | 84,672,378.00 | (197,178.00) | 100.2 |
| 210401 | Бичиг хэрэг | 16,805,200.00 | 16,903,660.00 | (98,460.00) | 100.6 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | 8,000,000.00 | 7,661,900.00 | 338,100.00 | 95.8 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 6,500,000.00 | 6,276,810.00 | 223,190.00 | 96.6 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 27,070,000.00 | 23,952,526.00 | 3,117,474.00 | 88.5 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 26,100,000.00 | 29,877,482.00 | (3,777,482.00) | 114.5 |
| 2105 | Норматив зардал | 1,037,472,200.00 | 1,026,284,419.75 | 11,187,780.25 | 98.9 |
| 210501 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 812,771,700.00 | 787,245,119.75 | 25,526,580.25 | 96.9 |
| 210502 | Хоол, хүнс | 204,700,500.00 | 219,111,800.00 | (14,411,300.00) | 107.0 |
| 210503 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 20,000,000.00 | 19,927,500.00 | 72,500.00 | 99.6 |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 58,400,000.00 | 59,405,860.00 | (1,005,860.00) | 101.7 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 45,000,000.00 | 46,042,960.00 | (1,042,960.00) | 102.3 |
| 210604 | Урсгал засвар | 13,400,000.00 | 13,362,900.00 | 37,100.00 | 99.7 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 70,788,800.00 | 70,126,657.00 | 662,143.00 | 99.1 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 49,012,800.00 | 48,848,635.00 | 164,165.00 | 99.7 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 14,000,000.00 | 14,000,000.00 | - | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 600,000.00 | 548,220.00 | 51,780.00 | 91.4 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 500,000.00 | 278,912.00 | 221,088.00 | 55.8 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 279,000.00 | 99,000.00 | 180,000.00 | 35.5 |
| 210807 | Газрын төлбөр | 2,997,000.00 | 2,997,000.00 | 0.00 | 100.0 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 50,000.00 | 50,000.00 | 0.00 | 100.0 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 3,350,000.00 | 3,304,890.00 | 45,110.00 | 98.7 |
| 2201 | Бараа үйлчилгээний бусад зардал | 59,234,400.00 | 62,373,510.00 | (3,139,110.00) | 105.3 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 24,000,000.00 | 28,184,710.00 | (4,184,710.00) | 117.4 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 35,234,400.00 | 34,188,800.00 | 1,045,600.00 | 97.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 426,000,000.00 | 100,511,695.00 | 325,488,305.00 | 24.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 426,000,000.00 | 100,511,695.00 | 325,488,305.00 | 24.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 420,000,000.00 | 95,824,982.00 | 324,175,018.00 | 22.8 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 6,000,000.00 | 4,686,713.00 | 1,313,287.00 | 78.1 |
| 13 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 6,879,699,770.20 | 6,268,737,574.73 | 606,962,195.47 | 95.0 |
| 1340 | НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 5,857,491,700.00 | 5,823,597,790.00 | 29,893,910.00 | 99.5 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 5,857,491,700.00 | 5,823,597,790.00 | 33,893,910.00 | 99.5 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 766,534,400.00 | 445,139,784.73 | 321,394,615.27 | 105.8 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 135,305,200.00 | 143,132,781.73 | (7,827,581.73) | 105.8 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 631,229,200.00 | 302,007,003.00 | 329,222,197.00 | 47.8 |
| 4 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 255,673,670.20 | | 255,673,670.20 | 0.0 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 255,673,670.20 | | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 2,880,276.87 | | 0.0 |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | | | | 0.0 |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 192 | 192 | - | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 165 | 165 | - | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 26 | 26 | - | 100.0 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 15.9 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 15.9 сая төгрөгийн 2 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 15.9 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Төлбөртэй тусламж үйлчилгээний нэмэлт орлого төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг орлогын нэр төрлөөр, сар улирлаар хийж, захирлын тушаалаар батлуулж мөрддөггүй, зөвхөн тушаасан төлбөрийн дүнгээр орлогоор хүлээн зөвшөөрдөг, бөөн дүнгээр нь төлөвлөж, орлого төвлөрүүлэх, зарцуулах журмыг боловсруулж мөрдөөгүй байна. | 1 | | | | | | 1 | - | | | | |
| 2023 онд нийлүүлсэн ашиглалтын хугацаа дууссан эм эмнэлгийн хэрэгслийн үлдэгдэлтэй | 1 | 15,941.9 | | | | | 1 | 15,941.9 | | | | |
| **Дүн** | **2** | **15,941.9** | | | | | **2** | **15,941.9** | | | | |

Хүрээ амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1 албан шаардлага хүргүүлэв.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| *Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил* | | | | | | |
| Тус эмнэлгийн өөрийн эзэмшилд буй 94.05 м.кв газрын кадастрын зураг болон дахин давтагддаггүй дугаар зэрэг нь иргэн Б-д олгогдсон архитектур төлөвлөлтийн дугаар болон кадастрын зураг зэрэг баримт бичигтэй давхцаж, газрын эзэмшлийн маргаан үүссэн | 1 | - | 1 | - | | |
| **Дүн** | **1** | **-** | **1** | **-** | | |